



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 357

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Сум, суурин газрын цахилгаан хангамж, шугам сүлжээ, дэд станц /Увс аймаг, Зүүнхангай, Өмнөговь, Өндөрхангай сум/” барилга угсралтын ажлын хүрээнд бий болсон нийт 1,086,523,873.00 (нэг тэрбум наян зургаан сая таван зуун хорин гурван мянга найман зуун далан гурав) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу “Увс цахилгаан түгээх сүлжээ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Увс цахилгаан түгээх сүлжээ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Г.Заяабаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх, бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001792

17-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 07 дугаар сарын 27-н өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



"УВС ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Бүртгэх дүн (төгрөг)
1	Увс аймаг Өмнөговь сумын 0.4 кВ-ын ЦДАШ	2023	иж бүрдэл	1	389,681,741.00
2	Увс аймаг Өндөрхангай сумын 0.4 кВ-ын ЦДАШ	2021	иж бүрдэл	1	307,027,603.00
3	Увс аймаг Зүүнхангай сумын 0.4 кВ-ын ЦДАШ	2021	иж бүрдэл	1	389,814,529.00
Нийт дүн					1,086,523,873.00
					(нэг тэрбум наян зургаан сая таван зуун хорин гурван мянга найман зуун далан гурав)